



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/224

Мандалговь

Залуус хорооллын нийтийн эзэмшлийн
зам талбайн тохижилтын ажлын
гэрээг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Иргэний хуулийн 355 дугаар зүйлийн 355.1, 355.6, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, “Залуус хорооллын нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт”-ын ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий нөхцлийн 42 дугаар зүйлийн 42.2.2, “Залуус хорооллын нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт” ДУГАОНӨГ/202101007 дугаартай 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан гэрээний 11, 18 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Залуус хорооллын нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт”-ын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “ЭЭБО Пропертиз” ХХК нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тул 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан 667,982,694 (зургаан зуун жаран долоон сая есөн зуун наян хоёр мянга зургаан зуун ерэн дөрөв) төгрөгийн өртөг бүхий ажил гүйцэтгэх гэрээг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн цуцалсугай.

2. “Залуус хорооллын нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилтын ажил”-ын хийгдээгүй үлдсэн ажил болох 133,726,468 (нэг зуун гучин гуран сая долоон зуун хорин зургаан мянга дөрвөн зуун жаран найм) төгрөгийн төсөвт өртөгт багтаан гүйцэтгэгчийг дахин сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Л.Доржбат), Орон нутгийн өмчийн газар (Б.Адъяасүрэн) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4823100-41